

Хүчтэй. Хамтдаа.

АГУУЛГА

АЛСЫН ХАРАА	5
ЭРХЭМ ЗОРИЛГО	5
БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС	5
ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	6
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	7
КОМПАНИЙН ТУХАЙ	8
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	9
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	10
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	11
ХҮНИЙ НӨӨЦ	12
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ	13
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	14
ХАРИЛЦАГЧИЙН ТҮҮХ	16
2014 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	17
САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	19
САНХҮҮГИЙН БАЙДАЛ	20
ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ	21
ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	22
ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ	24
АУДИТЫН ТАЙЛАН	26
ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД	31

АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсад банкны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Харилцагч төвтэй, шинэлэг үйлчилгээ

Сэтгэл ханамжтай ажиллагсад

Тогтвортой өндөр өгөөж

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа

Нийгмийн хариуцлага

ТУЗ-ИЙН ДАРГА Ч. ГАНХУЯГ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хамтран ажилладаг түнш, харилцагч таны энэ өдрийн амар амгаланг эрье!

Ард Санхүүгийн Нэгдэл буюу хуучнаар Equity Investment Trust (EIT) ХХК Ард Кредит банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгч болж, энэ компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор удирдагыг нь хэрэгжүүлж ажилласан анхны бүтэн жилийн тайланг та бүхэндээ толилуулж байгаадаа баяртай байна.

2014 он Ард Холдингсын хувьд шинэ нэрэн дор, шинэ баг бүрэлдэхүүнээр том зорилго дэвшүүлэн ажилласан анхны жил болж өндөрлөлөө. Бид өнгөрөгч онд лого, бэлгэдлээ гарган баталж, “Хүчтэй, Хамтдаа” уриан дор цоо шинэ үндэсний санхүүгийн нэгдлийн суурийг тавихаар шамдан ажилласан болно. Монголын эдийн засгийн нөхцөл байдал амаргүй байсан боловч бидний хувь нийлүүлсэн компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлж, санхүүгийн

хувьд тогтвортой үзүүлэлт гаргасан он жил боллоо. Бид үйл ажиллагааны бүтцийн хувьд хамгийн цомхон бөгөөд чадварлаг бүрэлдэхүүнээр ажиллаж, санхүүгийн чанд сахилга батыг мөрдлөг болгон эдийн засгийн энэ хүндрэлтэй үеийг амжилттай даван туулж байна. Энэ жилийн хувьд бидний гол зорилго нь Монголын Хөрөнгийн Бирж дээр өөрийн хувьцаагаа нээлттэй арилжаалдаг болох явдал мөн.

Ард Кредит нь өнгөрсөн жил шинээр бондын хөрөнгийг амжилттай босгож, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан болон арилжааны банкнаас зээлийн санхүүжилт татан авч, итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэн нийт 300 гаруй сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энэ онд Кредит маань хувь нийлүүлэгчиддээ анх удаа ашгийн 30 гаруй хувиа ногдол ашгаар хуваарилах шийдвэрийг гаргалаа. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь корпорацийн зохистой засаглалын тэргүүний туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, гүйцэтгэх удирдлагад бодлогын чиглэл өгөн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж дадлаа. ТУЗ болон хороодын хурлууд тогтмол явагдаж, ТУЗ гүйцэтгэх удирдлагатайгаа нягт, ойр ажилласны үр дүн байгууллагын бүх үзүүлэлтээр илэрч байгааг мэдэгдэхэд таатай байна. Өмнөх жилийн нэгэн адил, 2014 оны санхүүгийн үр дүнд BDO Audit баталгаажуулалт хийснээр Ард Кредит бусад өрсөлдөгчдөөсөө онцгойрч гарч ирж байгаагийн мөн нэгэн илрэл, бидний ил тод байдлыг эрхэмлэж, зарчимдаа тууштай байгаагийн мэдэгдэл билээ.

2015 онд Ард Кредит борлуулалтын шинэ суваг нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүн гаргаж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Бид хөдөөгийн хадгаламж зээлийн хоршоодтой хамтын ажиллагаагаа нягтруулах бөгөөд зээлийн багцаа нугалах бодолтой байна. Бидний хамгийн том зорилт бол гадаад эх үүсвэр татан оруулж ирэх явдал мөн.

Ингээд та бүхэн гүйцэтгэх удирдлагын зүгээс толилуулж байгаа энэхүү жилийн тайлантай тухтай танилцана уу. Та бүгдийн ажил үйлсэд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч. ГАНЗОРИГ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье. Ард Кредит ББСБ-ын анхны жилийн тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

2014 он бидний хувьд шинэ хөрөнгө оруулалт хийгдсэнээс хойш шинэ бүтэц бүрэлдэхүүнээрээ бүтэн ажилласан анхны жил гэдгээрээ онцлогтой жил болон өнгөрлөө. Компанийн удирдлагын баг 2014 онд компанийн засаглал болон дотоод үйл ажиллагааны үндэс суурийг зөв тавьж, төлөвшүүлэх тал дээр төвлөрөн ажиллахын зэрэгцээ компанийн өсөлт, ашигт ажиллагааг өндөр түвшинд барихыг зорилоо.

2014 онд Монгол Улсын эдийн засгийн орчин сайнгүй байсан хэдий ч компанийн хамт олны хүчин чармайлтын үр дүнд бидний нийт хөрөнгийн хэмжээ 86 хувь өсч 3.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 300 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2014 онд бид Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл авч, анхны хаалттай өрийн бичгээ гарган дотоодын хөрөнгө оруулагчдад амжилттай борлуулсан, мөн Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авч дотоодоос санхүүжилт татсан амжилт бүтээл дүүрэн жил боллоо. Ард Кредит нь Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зориулалттай бөөний зээлийг хүлээн авч, Хөдөөгийн Хадгаламж Зээлийн Хоршоодод бөөний зээл олгож эхэлсэн явдал нь компанийн түүхэнд мөн тодоор тэмдэглэгдэх үйл явдал боллоо.

2015 оны хувьд бид гадны бичил санхүүгийн сангуудаас санхүүжилт татах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулан дэвшилтэт технологи дээр суурилсан шинэ арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилт тавьж байна.

КОМПАНИЙН ТУХАЙ

Ард Кредит ББСБ ХХК (Ард Кредит) нь 2011 оны 4 дүгээр сард үүсгэн байгуулагдан Монгол Улсад бичил болон жижиг зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл (АСН)-ийн хөрөнгө оруулалттай үндэсний компани юм. Бидний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан бичил болон жижиг зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхэд оршино.

Ард Кредит нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны тусгай зөвшөөртэйгөөр Зээлийн үйл ажиллагаа, Валютын арилжаа, Хөрөнгө оруулалт болон санхүүгийн зөвлөгөө өгөх, Итгэлцэлийн үйлчилгээ зэрэг санхүүгийн үйл ажиллагаа амжилттайгаар явуулж ирлээ.

2013 онд компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлтүүд орсон бөгөөд бид АСН-ийн шууд хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгдөж салбартаа олон жилийн мэдлэг, туршлага хуримтлуулсан удирдлагын багийг бүрдүүлэн ажиллаж байна.

Шинэ хөрөнгө оруулагчдыг татан оруулж ирснээр бид компанийн стратеги бодлогыг шинэчилсэн бөгөөд дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар үйлчилгээнийхээ цар хүрээг тэлж, өндөр хурдаар өсөн дэвшиж зах зээл дээрх тэргүүний байр сууринд гарах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

2011

2011 оны 4 дүгээр сард Интергрупп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.

2013

2013 онд шинэ хөрөнгө оруулалт хийгдэж компанийн үйл ажиллагаа идэвхжиж шинэ багаар, шинэ төлөвлөгөөтэй ажиллаж эхэлсэн.

2013 оны 12 дугаар сард компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон бөгөөд бид АСН-ийн шууд хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгдсөн.

2014

2014 оны 4 сард итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан.


2014 оны 2 сард анхны Хаалттай өрийн бичгээ гаргасан.

2014 оны 9 сард БСХС-тай хамтран ажиллаж эхэлсэн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Ард Кредит нь 4 нь хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хамгийн том буюу 50 хувийг АСН эзэмшиж байна. АСН нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийх, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. АСН-ийн бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз, Ард

Актив, Ард Капитал Менежмент болон Хөрөнгө Оруулалтын Итгэлцлийн Сан багтаж байна. АСН-ийн хөрөнгө оруулалтын сангаас Техник Технологийн Дээд Сургууль, Номын Хишиг, Уайлд Дижитал Эйжэнси, ТэнГэр Системс зэрэг компанид хөрөнгө оруулалт хийн удирдлагад нь идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгож ажиллаж байна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн ТУЗ нь нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 1 гишүүн хараат бусаар ажиллаж байна. Бид салбартаа компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн жишиг байгууллага болохыг зорьж байна.



Чулуун ГАНХУЯГ
Гүйцэтгэх захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл



Барамсай ГАНБАТ
Гүйцэтгэх захирал,
Техник Технологийн Дээд
Сургууль



Сэдбазар ГЭРЭЛТУЯА
Гүйцэтгэх захирал,
Мон-Интернэшнл ХХК



Ванданцэрэн
БАЯРЖАРГАЛ
Үйл ажиллагаа эрхэлсэн
захирал,
Интергрупп ХХК




Нэмэхбаатар
ЭРДЭМБАЯР
Гүйцэтгэх захирал,
Заг ХХК




Чулуун ГАНЗОРИГ
Гүйцэтгэх захирал,
Ард Кредит ББСБ ХХК

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХҮНИЙ НӨӨЦ

Бид 2014 онд нийт 9 орон тооны ажилтантай багаар ажилласан бөгөөд өмнөх оноос нийт орон тооны ажилтан 25 хувиар өссөн байна. Бид ажиллагсдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсрон өнгөрүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Ард Кредит нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлд заасан ББСБ-ын эрхлэхийг зөвшөөрсөн 10 төрлийн үйл ажиллагаанаас дараах 5 төрлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа бөгөөд бидний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь зээлийн үйлчилгээ юм.

Үүнд:

- Зээл;
- Гадаад валютын арилжаа;
- Хөрөнгө оруулалт, мөн санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- Хаалттай өрийн бичиг гаргах;
- Итгэлцлийн үйлчилгээ.

Зээлийн үйл ажиллагааг эрхлэхдээ зээлдэгчтэй урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг эрхэмлэх, бичил болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр шинээр бий болгоход зээлийн бодлогыг чиглүүлэн ажилладаг.



Бичил бизнесийн зээл

Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийг эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлнэ



Цалингийн зээл

Иргэний өрхийн хэрэглээнд зориулагдсан цалингийн зээл



Жижиг, дунд бизнесийн зээл

Жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ



Хоршоо хөгжил зээл

Алслагдсан хөдөө, орон нутгийн иргэдийг ХЗХ-гоор дамжуулан санхүүжүүлнэ



Шуурхай зээл

Тээврийн хэрэгсэл, хашаа байшин, газар, орон сууц барьцаалан иргэдийн богино хугацааны санхүүгийн хэрэгцээг санхүүжүүлнэ



Төслийн зээл

БСХС-гийн Тогтвортой амьжиргаа II төслийн ядуурлыг бууруулах зээл

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургууль

Ард Санхүүгийн Нэгдэлийн хамт олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургууль дээр зочилж тус сургуулийн 310 хүүхдэд тусламж болгон дүрэмт хувцас авахад зориулан 5,000,000 төгрөгийн хандив өргөсөн бөгөөд тоглоом, хичээллийн хэрэглэл гардуулж хүүхдүүдийн гарыг цайлгалаа. Энэхүү үйл ажиллагаанд оролцсон 29 дүгээр сургуулийн багш сургагч хамт олонд талархал илэрхийлж амжилт хүсье.



Паралимпийн тамирчин Э.Содномпилжээ

Ард Кредитийн хамт олон хүндийг өргөлтийн паралимпын тамирчин Э.Содномпилжээг ивээн тэтгэж ажиллаж ирсэн билээ. Содномпилжээ нь 2014 онд Сөүлд болсон Азийн наадмаас хүрэл медаль, 2015 онд Дубайд болсон Дэлхийн цомоос мөнгөн медаль эх орондоо авчраад байна.



Спрайт Лиг 2014 Ард ИЙГЛС баг

Бид "Монголын Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбоо"-ноос зохион байгуулдаг үндэсний "Спрайт" лигийн тэмцээнд "Ард Ийглс" багийг ивээн тэтгэж ажилласан бөгөөд спорт соёлын арга хэмжээ болон залуусын эрүүл мэндийг дэмжиж ажилладаг.



Дуулиан 2020

Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор хүүхдийн "Дуулиан-2020" хөл бөмбөгийн тэмцээн 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдаж Ард Кредитийн хамт олон Нийслэлийн 23 дугаар дунд сургуулийг энэхүү тэмцээнд ивээн тэтгэж оролцуулдаг билээ.



Бариад суллах аян

Бид "Catch and Release" буюу бариад суллах утагтай аянг дэмжиж оролцож байгаа анхны байгууллага болсондоо баяртай байна. Мөн Цэнгэг спорт загасчлалын клубээс санаачилсан Мод тарих аянг 2014 оны 5 дугаар сарын 8-наас 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж Төв аймгийн Мөнгөнморьт сумын Жаргалант багт орших Далхай нуурын орчимд 1000 ширхэг 3 настай нарс мод тарьж, модоо хамгаалах хашааг барих ажлыг хийж гүйцэтгэлээ. Мод тарих аянд нэгдэж байгаль дэлхийгээ хайрлах, ширгэж буй хос Далхай нуурыг сэргээхэд өчүүхэн ч болов хувь нэмрээ оруулсан нэг хүсэл зорилготой залуучууддаа талархал илэрхийлье.



Хөдөөгийн бичил санхүүгийн зээл олгогчдын холбоо

Бид 2013 оноос Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой (ХБСХДХ) хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү холбоо нь Монгол улсын нутгаар тархан байршсан 50 гаруй хадгаламж зээлийн хоршоог өөртөө нэгтгэсэн байгууллага юм. Ард Кредит нь холбооны гишүүн хоршоодод нэмэлт санхүүжилт болон сургалт, зөвөлгөө өгөх үүднээс энэхүү хамтын ажиллагааг эхлүүлэн Хоршоо Хөгжил хэмээх зээлийн бүтээгдэхүүн гарган ажиллаж байна.

ХАРИЛЦАГЧИЙН ТҮҮХ

Д.ЭРДЭНЭБААТАР ЗАХИРАЛТАЙ ОРОС ЧАНАР ХХК



Орос Чанар ХХК нь анх 2001 онд цэвэр ус, ундааны цех нээн ажиллуулснаар бизнесийн гараагаа эхлүүлсэн бөгөөд үйл ажиллагаа нь амжилттай байсан тул 2007 оноос хүнсний хагас боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Орос Чанар ХХК нь өдөрт 500-800кг “Орос Чанар” савхан болон төрөл бүрийн хэрчилттэй гоймон, 4000-5000 ширхэг хэрчсэн гурил, 2000-5000 кг “Орос Чанар” бууз, банш үйлдвэрлэх хүчин чадалтай болж 1000 гаруй байнгын худалдан авагч, хэрэглэгчтэй болсон.

2013 онд үйлдвэрлэл өргөжихийн хирээр өөрийн ажлын байрыг бий болгон тохижуулснаар эргэлтийн хөрөнгө буурсан. Манай байгууллагаас эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор жижиг дунд бизнесийг дэмжих зээл авснаар богино хугацаанд санхүүгийн хэрэгцээг хангаж үйлдвэрлэлээ бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах боломжтой болсон байна.



Орос Чанар ХХК-н үйлдвэрийн үйл явц

2014 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Компанийн дотоод үйл ажиллагааг тогтворжуулж, байгууллагын үндэс суурийг тавьж, төлөвшүүлэх тал дээр төвлөрөн ажилласан.

Компанийн лого болон брендбүүк, цахим хуудасыг шинэчлэн хөгжүүлсэн.

Санхүүжилт:

- Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангийн Тогтвортой амжиргаа төслийн зээл.
- Дотоодын банк-наас зээлийн санхүүжилт авсан.
- СЗХ-ны зөвшөөрөлтэйгөөр хаалттай өрийн бичиг гарган амжилттай борлуулсан.
- Итгэлцэлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ноос аван санхүүжилт босгосон.

Зээлийн үйл ажиллагааг бичил бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглүүлсэн.

- Нийт 5.8 тэрбум төгрөгийн зээлийг 294 харилцагчид олгосон.
- 11-н ХЗХ-нд 213 сая төгрөгийн зээл олгосноор хөдөө орон нутгийн иргэдэд зээлийн үйлчилгээг хүргэж эхэлсэн.

7 удаагийн ТУЗ-ийн хурлыг зохион байгуулж компаний засаглал, тайлагнал, ил тод байдлыг сайжруулсан.

Ажлын байранд засвар хийснээр ажиллагсдадаа эрүүл, таатай орчинд хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлсэн.

Ажиллагсдаа мэргэжлийн сургалтанд хамруулан ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчдэдээ анхны ноогдол ашгийг хуваарилсан.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2014 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт удааширч, төгрөгийн ханш унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалт багассан байдалтай байсан хэдий ч компанийн нийт хөрөнгийн хэмжээ 1.8-аас 3.4 тэрбум төгрөгт хүрч 86 хувь, цэвэр зээлийн багц 1.6-аас 2.6 тэрбум төгрөг болж 60 хувь өссөн үзүүлэлттэй жил болон өнгөрлөө. Энэхүү өсөлтийг бид дотоодын эх үүсвэрүүдээс санхүүжүүлсэн ба гол эх үүсвэрүүдийг нэрлэвэл:


1. Анхны хаалттай өрийн бичгээ гаргаж амжилттайгаар борлуулсан,
2. Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангийн бөөний зээлийг авсан,
3. Дотоодын банкнаас санхүүжилт татсан,

4. Итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчдаас эх үүсвэр татсан зэрэг орж байна.

Тайлант хугацаанд бид нийт 5.5 тэрбум төгрөгийн зээлийг 294 харилцагч нарт олгосон байна. Эдийн засгийн таагүй нөхцөл байдал нь харилцагчдын зээл төлөх чадварт сөрөг нөлөө үзүүлж байсан ч манай хамт олны шургуу ажлын үр дүнд оны эцэст чанаргүй зээлийн үлдэгдлийн 3 хувьд барьж ажиллалаа.


Оны эцэст татварын дараах цэвэр ашиг 300 сая төгрөгт хүрэн өмнөх оноос 150 хувь өссөн дүнтэй гарч, компанийн дундаж өөрийн өгөөжийг 21 хувьд хүрлээ.

САНХҮҮГИЙН БАЙДАЛ



Шалгуур үзүүлэлтүүд %	2011	2012	2013	2014
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	102	100	76	55
Том зээлдэгчид олгосон зээлийн харьцаа	19	27	13	18
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа	23	2	1	5
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	5774	2482	49	46
Үндсэн хөрөнгийн харьцаа	0	0	1	6

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ



Тайлант хугацаанд бид нийт 5.5 тэрбум төгрөгийн зээлийг 294 харилцагч нарт олгосон бөгөөд оны эцсийн байдлаар нийт 2.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн багцтай, 172 харилцагчтайгаар жилээ өндөрлөлөө. Өнгөрсөн хугацаанд бид зээлийн бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмж, үйлчилгээгээ сайжруулан ажиллахын хажуугаар зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон хүнд хүрэхийг зорилоо.

Нийт зээлийн 88 хувийг бизнесийн үйл ажиллагааг дэмжих зориулалтаар олгосон бөгөөд 12 хувийг харилцагчдын бусад хэрэглээнд зориулан олгожээ.

Бичил зээл (30 сая төгрөг хүртэлх зээл)-ийн тоо 144-д хүрч, өмнөх оноос 99 зээлдэгчээр буюу 2.2 дахин өслөө.

2013 оноос бид Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд хөдөөгийн хадгаламж зээлийн хоршооны гишүүдэд хүрэн ажиллаж эхэлсэн. Оны эцсийн байдлаар орон нутагт байрших зээлийн үлдэгдэл 226.3 сая төгрөг болж өссөн байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2014 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 7.8 хувьд хүрсэн бөгөөд уул, уурхайн салбар 24.2 хувь, хөдөө аж ахуй 14.4 хувь, бусад салбар 1.8 хувь тус тус өссөн үзүүлэлттэй байна. 2011 онд 17.3 хувиар өсч байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурдац ийнхүү саарахад экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр унасан, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан нь нөлөөлөв. Эдийн засгийн өсөлтийн хурдац саарч, бизнесийн идэвхжил суларч байгаагаас 2014 онд худалдааны салбар 6.9 хувийн уналттай гарлаа.

2014 оны эцэст улсын инфляцийн түвшин 11 хувьтай гарлаа. Инфляцийн бүтцийг харвал махны болон шатахууны инфляци буурсан бөгөөд валютын ханшийн өсөлттэй холбоотойгоор импортын барааны бүлгийн инфляци 2014 онд өссөн дүнтэй гарлаа. Гадаад худалдаа 2014 оны гүйцэтгэлээр нийт экспорт өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар өсч, нийт импорт 17.6 хувиар бууран гадаад худалдааны тэнцэл 537.9 сая долларын ашигтай гарлаа. Эдийн засгийн идэвхжил саарсан нь нийт эрэлтийг бууруулж, улмаар нийт импортын хэмжээ буурахад хүргэсэн байна.

Хүн ам
3.0 сая


Газар
1.6 сая км²

ДНБ-ий өсөлт
7.8 %

Ажилгүйдлийн түвшин
7.7 %

Дунд боловсролын түвшин
97.3%

Хүний хөгжлийн индекс
103



ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ


2014 онд цэвэр дүнгээр ББСБ-уудын тоо 115-аар нэмэгдсэн бөгөөд тайлант хугацааны эцэст нийт 378-н ББСБ Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 323-н ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Оны эцсийн байдлаар ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 508 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь 2013 онтой харьцуулахад 33 хувиар өссөн дүн юм.


Энэхүү өсөлтийн дийлэнх буюу 59 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө өссөнтэй холбоотой юм.

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт хөрөнгө 508 тэрбум, зээлийн багц 303 тэрбум, эзэмшигчдийн өмч 332 тэрбум, хувьцаат капитал 258 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийт хөрөнгийн 2.2 хувьтай, зээлийн багцын 2.4 хувьтай, эзэмшигчдийн өмчийн 15.6 хувьтай, хувьцаат капиталын 65.6 хувьтай тус тус тэнцэж байна.


Нийт ББСБ-ын тооны өөрчлөлт




Нийт ББСБ-ын активын өсөлт
(тэрбум төгрөг)



Валютын ханш
(Доллар)




Нийт зээл, зээлийн чанар
(тэрбум төгрөг)




● Чанаргүй ● Хугацаа хэтэрсэн ● Хэвийн ● Нийт зээл

Зээлийн сарын дундаж хүү
(хувь)



● ББСБ-ын зээлийн хүү ● Банкны зээлийн хүү

Улсын дундаж цалин
(сараар, сая төгрөг)



№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо /2014/
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	129
	Зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53
2	Зээл	323
3	Факторингийн үйлчилгээ	16
4	Төлбөрийн баталгаа гаргах	11
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6
7	Итгэлцлийн үйлчилгээ	24
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх	29

АУДИТЫН ТАЙЛАН



Tel: +976 77404041
Fax: +976 77451150
www.bdo.mn

Level 10, AB Center Building,
University Street,
11 th Khorooolol, khoro-6,
Sukhbaatar District-14193,
Ulaanbaatar, Mongolia

Утас: +976 77404041
Факс: +976 77451150
www.bdo.mn

АБ Цэнтр, 10 давхар
СБД-6, 11-р хороолол
Улаанбаатар, Монгол улс
14193

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРД КРЕДИТ ББСБ” ХХК -ийн хувь нийлүүлэгчдэд

Санхүүгийн тайлангийн талаар

Бид “Ард Кредит ББСБ” ХХК-ийн (цаашид “ББСБ” гэх) 6-33 дугаар хуудсанд тусгагдсан 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Ашиг алдагдал бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Үүнд санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг зохиож, ажиллуулан, хэвийн түвшинд сахих; тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх; нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, “Ард Кредит ББСБ” ХХК-ийн 2014 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Ард Кредит ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Огноо: 2015.03.30

2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн АШИГ, АЛДАГДАЛ БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тэм	2014 он мян.төг	2013 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	889,298	261,179
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(210,295)	(17,734)
Хүүгийн цэвэр орлого		679,003	243,445
Шимтгэлийн орлого	6	47,920	20,072
Гадаад валютын арилжааны орлого/(зардал)	7	(3,029)	(1,153)
Хүүгийн бус цэвэр орлого		44,891	18,919
Үйл ажиллагааны орлого		723,894	262,364
Ажиллагсадтай холбогдолтой зардал	8	(157,053)	(73,979)
Үйл ажиллагааны бусад зардал	9	(148,753)	(56,962)
Эрсдлийн нөөцийн зардал	10	(57,791)	(8,893)
Үйл ажиллагааны ашиг		360,297	122,529
Үйл ажиллагааны бус бусад орлого/(зардал)	11	(22,184)	13,029
Татварын өмнөх цэвэр ашиг		338,113	135,558
Орлогын албан татвар	12	(38,082)	(12,254)
Татварын дараах цэвэр ашиг		300,031	123,305
Нэгж хувьцаанд ногдох ашиг-Төгрөгөөр	13	30.00	16.44

2014 оны 12 сарын 31-ний өдрөөрх
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	2014 оны 12 сарын 31 мян.төг	2013 оны 12 сарын 31 мян.төг
АКТИВ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	14	502,570	143,705
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	15	2,658,162	1,658,140
Өмч, барилга, тоног төхөөрөмж-цэвэр	16	197,816	16,804
Биет бус хөрөнгө-цэвэр	17	4,000	4,750
Бусад актив	18	25,707	3,745
НИЙТ АКТИВ		3,388,254	1,827,144
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Дүрмийн сан	19	1,000,000	1,000,000
Нэмж төлөгдсөн капитал	20	100,000	100,000
Хуримтлагдсан ашиг / (алдагдал)		480,839	180,808
Нийт өмч		1,580,839	1,280,808
ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээлийн эх үүсвэр	21	248,864	479,689
Өрийн бичиг	22	250,000	-
Богино хугацаат зээлийн эх үүсвэрийн өглөг	23	760,059	52,860
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	24	500,828	-
Бусад пассив	25	47,665	13,788
Нийт өр төлбөр		1,807,415	546,337
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		3,388,254	1,827,144


2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал мян.төг	Хуримтлагд -сан ашиг мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	НИЙТ мян.төг
2013 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	500,000	57,503	-	557,503
Гаргасан хувьцаа	500,000	-	-	500,000
Тайлант хугацааны цэвэр ашиг	-	123,305	-	123,305
Нэмж төлөгдсөн капитал			100,000	100,000
2013 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	1,000,000	180,808	100,000	1,280,808
Гаргасан хувьцаа				-
Тайлант хугацааны цэвэр ашиг	-	300,031	-	300,031
Нэмж төлөгдсөн капитал				-
2014 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	1,000,000	480,839	100,000	1,580,839

2014 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2014 он мян.төг	2013 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг /(алдагдал)	338,113	135,558
Тохируулга:		
Элэгдэл, хорогдол	15,801	1,905
Зээлийн эрсдлийн нөөцийн зардал	57,791	8,893
Хүүгийн орлого	(889,298)	(261,179)
Хүүгийн зардал	181,186	17,734
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	(296,406)	(97,089)
Зээл, урьдчилгааны өсөлт	(1,037,819)	(1,088,709)
Бусад активын (өсөлт)/бууралт	(21,961)	(3,745)
Дотоодын бусад байгууллагаас татсан эх үүсвэрийн (бууралт)/ өсөлт	1,227,201	532,549
Бусад пассивын (бууралт)/ өсөлт	(843)	3,634
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлт	166,577	(556,272)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгө	(129,829)	(653,360)
Төлсөн орлогын албан татвар	(27,321)	(6,308)
Хүлээн авсан хүү	869,305	239,419
Төлсөн хүү	(157,227)	(16,047)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон /(түүнд шингэсэн) цэвэр мөнгөн гүйлгээ	554,928	(436,296)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(195,763)	(17,480)
Худалдан авсан биет бус хөрөнгө	(300)	(5,000)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(196,063)	(22,480)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гаргасан хувьцаат капитал	-	600,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	600,000
Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	358,865	141,224
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эхний үлдэгдэл	143,705	2,481
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эцсийн үлдэгдэл	502,570	143,705

Хамтран ажилладаг байгууллагууд:



Хүчтэй. Хамтдаа.



Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар Дүүрэг, Олимпын гудамж,
12/1, 1-р хороо, ДиБи Бьолдинг
Утас: +976 77003322
И-мэйл: info@ardcredit.com
Вэбсайт: www.ardcredit.com